



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндун сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/111/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: А.Даваасүрэн

Утас: 70003775, 88883776

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
Албан шаардлага	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.2.25 № 263

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020968

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>46,235,183.09</u>	<u>47,964,346.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	46,235,183.09	47,964,346.00
354	Хангамжийн материал	46,235,183.09	47,964,346.00
35410	Бичиг хэргийн материал	4,320,500.00	5,820,205.00
35420	Аж ахуйн материал	19,837,063.00	20,732,363.00
35460	Хүнсний материал	3,251,900.00	2,746,312.00
35470	Бусад хангамжийн материал	18,825,720.09	18,665,466.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>945,335,405.66</u>	<u>898,728,792.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	945,335,405.66	898,728,792.18
392	Биет хөрөнгө	928,339,405.66	881,732,792.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	916,263,576.13	916,263,576.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(69,227,924.51)	(89,498,322.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,000,000.00)	(3,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,398,824.50	64,620,524.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,993,381.60)	(36,047,626.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,357,613.50	64,937,603.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,683,976.31)	(49,328,339.11)
39209	Зам, гүрийн байгууламж	20,612,936.95	20,612,936.95
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,681,613.00)	(10,120,911.16)
39217	Ном	293,350.00	293,350.00
393	Биет бус хөрөнгө	16,996,000.00	16,996,000.00
39301	Программ хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,100,000.00)	(1,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,996,000.00	16,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>991,570,588.75</u>	<u>946,693,138.18</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>991,570,588.75</u>	<u>946,693,138.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	991,570,588.75	946,693,138.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	741,821,165.00	741,821,165.00
51101	Өмч: - төрийн	741,821,165.00	741,821,165.00
512	Хуримтлагдсан үр дүн	214,132,026.10	169,254,575.53
51210	Өмнөх үеийн үр дүн	245,380,656.63	214,132,026.10
51220	Тайлант үеийн үр дүн	(31,248,630.53)	(44,877,450.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,617,397.65	35,617,397.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>991,570,588.75</u>	<u>946,693,138.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	461,003,107.50	490,005,567.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,510,005.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,510,005.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	10,007,007.50	2,510,005.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	89,900	2,510,005.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	450,996,100.00	487,495,562.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,181,100.00	429,604,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	412,181,100.00	429,604,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,533,262.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,533,262.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,815,000.00	49,358,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,815,000.00	49,358,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	492,251,738.03	534,743,014.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,251,738.03	534,743,014.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477,263,498.39	507,748,692.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,061,699.30	337,841,023.03
210101	Үндсэн цалин	254,797,384.30	215,162,431.22
210102	Нэмэгдэл	48,775,500.00	95,373,658.61
210104	Урамшуулал	16,488,815.00	27,304,933.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,687,487.11	44,130,212.17
210201	Тэтгэврийн даатгал	26,884,887.11	30,864,612.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,200,300.00	3,316,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,560,700.00	2,653,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	640,200.00	663,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,401,400.00	6,632,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,390,646.06	37,444,764.30
210301	Гэрэл, цахилгаан	15,849,430.06	17,505,352.30
210302	Түлш, халаалт	14,491,216.00	18,639,412.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,027,500.00	10,057,734.09
210401	Бичиг хэрэг	927,700.00	521,700.00
210402	Тээвэр, шатахуун	757,600.00	1,099,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,400.00	1,124,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	99,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,048,800.00	7,211,914.09
2105	Нормативд зардал	29,380,915.00	23,951,052.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	797,600.00	3,622,052.00
210502	Хоол, хүнс	28,583,315.00	18,810,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,519,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,750,000.00	5,849,997.00
210604	Урсгал засвар	3,750,000.00	5,849,997.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	108,000.00
210702	Дотоод албан томилолт	128,000.00	108,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	369,900.00	510,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,300.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,600.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,467,350.92	47,855,910.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	777,300.00	1,089,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,690,050.92	46,466,610.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,988,239.64	26,994,321.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,770,042.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,770,042.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,988,239.64	6,063,438.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,988,239.64	6,063,438.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13,160,840.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,160,840.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(31,248,630.53)	(44,737,447.21)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	140,003.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	140,003.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(140,003.36)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(31,248,630.53)	(44,877,450.57)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	214,132,026.10	991,570,588.75
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	214,132,026.10	991,570,588.75
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	214,132,026.10	991,570,588.75
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	214,132,026.10	991,570,588.75
Тайлант үеийн үр дүн	-	-	(44,877,450.57)	(44,877,450.57)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	169,254,575.53	946,693,138.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	450,996,100.00	487,495,562.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	450,996,100.00	487,495,562.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,181,100.00	429,604,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	412,181,100.00	429,604,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,533,262.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,533,262.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,815,000.00	49,358,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,815,000.00	49,358,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	450,996,100.00	487,495,562.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,996,100.00	487,495,562.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,007,860.36	460,501,240.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,061,699.30	337,841,023.03
210101	Үндсэн цалин	254,797,384.30	215,162,431.22
210102	Нэмэгдэл	48,775,500.00	95,373,658.61
210104	Урамшуулал	16,488,815.00	27,304,933.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,007,900.00	44,130,212.17
210201	Тэтгэврийн даатгал	27,205,300.00	30,864,612.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,200,300.00	3,316,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,560,700.00	2,653,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	640,200.00	663,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,401,400.00	6,632,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,390,646.06	37,444,764.30
210301	Гэрэл, цахилгаан	15,849,430.06	17,505,352.30
210302	Түлш, халаалт	14,491,216.00	18,639,412.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,010,900.00	9,782,480.00
210401	Бичиг хэрэг	821,200.00	521,700.00
210402	Тээвэр, шатахуун	757,600.00	1,099,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,400.00	1,124,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	99,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,138,700.00	6,936,660.00
2105	Нормативд зардал	32,632,815.00	23,445,464.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	797,600.00	3,622,052.00
210502	Хоол, хүнс	31,835,215.00	18,304,412.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,519,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,750,000.00	5,849,997.00
210604	Урсгал засвар	3,750,000.00	5,849,997.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	108,000.00
210702	Дотоод албан томилолт	128,000.00	108,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	386,600.00	510,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,600.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	639,300.00	1,389,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	639,300.00	1,089,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,988,239.64	26,994,321.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,770,042.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,770,042.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,988,239.64	6,063,438.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,988,239.64	6,063,438.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13,160,840.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,160,840.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	501,434,200.00	459,738,020.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,434,200.00	459,738,020.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,434,200.00	459,738,020.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,640,300.00	337,841,023.03
210101	Үндсэн цалин	214,855,400.00	215,162,431.22
210102	Нэмэгдэл	96,449,200.00	95,373,658.61
210104	Урамшуулал	20,335,700.00	27,304,933.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,771,100.00	44,130,212.17
210201	Тэтгэврийн даатгал	31,505,800.00	30,864,612.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,316,200.00	3,316,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,653,000.00	2,653,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	663,100.00	663,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,633,000.00	6,632,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,508,200.00	37,444,764.30
210301	Гэрэл, цахилгаан	23,568,200.00	17,505,352.30
210302	Түлш, халаалт	18,640,000.00	18,639,412.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,283,200.00	9,782,480.00
210401	Бичиг хэрэг	521,700.00	521,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	1,099,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,124,800.00	1,124,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	99,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,436,700.00	6,936,660.00
2105	Нормативд зардал	69,722,100.00	22,982,244.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,158,900.00	3,158,832.00
210502	Хоол, хүнс	66,563,200.00	18,304,412.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,519,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,850,000.00	5,849,997.00
210604	Урсгал засвар	5,850,000.00	5,849,997.00
2107	Томилолт, зочны зардал	150,000.00	108,000.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	108,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	510,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,089,300.00	1,089,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,089,300.00	1,089,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	501,434,200.00	459,738,020.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	452,076,000.00	416,443,259.20
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	452,076,000.00	416,443,259.20
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,358,200.00	43,294,761.30
132001	Орон нутгийн төсвөөс	49,358,200.00	43,294,761.30
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,533,262.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,533,262.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,220.00
2105	Нормативд зардал	463,220.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	463,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,770,042.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,770,042.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,770,042.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,533,262.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,533,262.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,533,262.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяндун сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяндун сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон боловсролын асуудал эрхэлсэн болон бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон цэцэрлэгийн насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшүүлэн хөгжлийг дэмжих зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндун сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 436,008.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,720.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,540.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 47,964.3 мянган төгрөг болж 1,729.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалтай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,087,824.0 мянган төгрөг болж 3,198.3 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь 3,198.3 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр хасагдсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 29,002.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 42,491.2 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 501,434.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 501,434.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 501,434.2 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 452,076.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 49,358.2 мянган төгрөг нийт 501,434.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 49,358.2 мянган төгрөг, улсын төсвөөс 429,604.1 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 478,962.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 459,738.0 мянган төгрөг буюу 95.9 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 19,224.3 мянган төгрөг буюу 4.1 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяндун сумын дээд шатны төсвийн захирагчаас 8,533.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нормативд зардалд 463.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 300.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 7,770.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяндун сумын Цэцэрлэг нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 469,361.1 мянган төгрөгийн 29 орлогын гүйлгээг байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Иймд Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасны дагуу мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгсөн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 969,155.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,531.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,531.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Тайлант онд 4,531.7 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын эр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяндун сумын цэцэрлэг	2	4.5	-	-	-	-	2	4.5	-	-